



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Аудитор: М.Энхжаргал  
Утас: 99812792  
Цахим хаяг: Enkhjargal.m@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ЗЭРЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.БААТАРБИЛЭГ ТАНАА**

2025.03.25 № 2/121  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### **Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### **Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 243,900 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй;
- Тайлант онд ижил нэршилтэй арга хэмжээнүүдийг дугаарлаж босго үнээс бууруулж шууд гэрээ байгуулж худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийсэн;
- Өмнө оны аудитаар өгсөн Тээлийн илч Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын бие даасан хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг сумын Засаг даргын тамгын газрын хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн ч 2020 оны шийдвэртэй газрыг бүртгэл тайланд тусгаагүй зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Зэрэг сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 736,075.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 184,210.9 мянган төгрөгөөр буюу 33.4 хувиар давуулан биелүүлжээ.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 965,918.0 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өссөн,

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



*Х.Болдбаатар*  
Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>709,778.4</b>	<b>935,689.0</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>303,435.0</b>	<b>495,221.4</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>283,635.0</b>	<b>284,668.6</b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>86,068.4</b>	<b>117,319.1</b>
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>36,640.0</b>	<b>38,480.0</b>
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,770,238.0</b>	<b>8,510,245.3</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7,770,238.0</b>	<b>8,510,245.3</b>
39200	Биет хөрөнгө	7,763,801.2	8,503,808.5
39300	Биет бус хөрөнгө	6,436.8	6,436.8
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,480,016.3</b>	<b>9,445,934.3</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>26,903.7</b>	<b>30,033.6</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>26,903.7</b>	<b>30,033.6</b>
41300	Өглөг	26,903.7	30,033.6
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,453,112.6</b>	<b>9,415,900.7</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>8,453,112.6</b>	<b>9,415,900.7</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	494,395.7	494,395.7
51200	Хуримтлагдсан үр дүн	7,873,144.2	8,835,932.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,572.7	85,572.7
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,480,016.3</b>	<b>9,445,934.3</b>

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,611,452.1</b>	<b>4,470,744.5</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>479,484.3</b>	<b>728,848.2</b>
110	Орлогын албан татвар	307,027.3	661,692.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	331,352.6	690,653.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-24,325.4	-28,960.5
113	Хөрөнгийн албан татвар	21,897.4	13,594.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	150,559.6	53,561.9
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,763,063.0</b>	<b>707,272.6</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,763,063.0	707,272.6
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,368,904.9</b>	<b>3,034,623.6</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,184,263.0</b>	<b>3,507,097.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,060,614.2</b>	<b>3,256,229.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,977,468.2</b>	<b>3,171,966.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,299.1	788,480.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,673.8	106,174.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,276.1	533,419.4
2104	Хангамж, бараа материалын зардал	459,877.8	534,155.5

2105	Нормативт зардал	513.0	480.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,435.0	9,668.2
2107	Томилолт, зочны зардал	8,180.1	9,385.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	370,293.8	710,367.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>487,919.5</b>	<b>479,834.9</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,083,145.9</b>	<b>84,263.7</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>123,648.8</b>	<b>250,867.5</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>3,427,189.1</b>	<b>963,647.2</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>3,427,189.1</b>	<b>963,647.2</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,318,362.6</b>	<b>4,591,415.7</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>479,484.3</b>	<b>728,848.2</b>
110	Орлогын албан татвар	307,027.3	661,692.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	331,352.6	690,653.0
1101	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	<b>-24,325.4</b>	<b>-28,960.5</b>
113	Хөрөнгийн албан татвар	21,897.4	13,594.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	150,559.6	53,561.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	30,156.9	14,834.3
1181	Газрын төлбөр	10,440.1	3,828.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	109,962.6	34,899.6
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>452,313.9</b>	<b>649,894.3</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>452,313.9</b>	<b>649,894.3</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,386,564.4</b>	<b>3,212,673.2</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,630,313.8</b>	<b>3,041,577.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,630,313.8</b>	<b>3,041,577.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,529,508.4</b>	<b>2,956,968.5</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	665,387.2	1,050,544.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,086.6	129,556.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	242,663.7	777,500.3
2104	Хангамж, бараа материалын зардал	29,897.8	47,495.4
2105	Нормативт зардал	501.1	480.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,685.6	14,796.8
2107	Томилолт, зочны зардал	8,180.1	9,385.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>406,158.4</b>	<b>784,983.6</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>86,947.7</b>	<b>142,225.4</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,100,805.4</b>	<b>84,608.7</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>688,048.8</b>	<b>1,549,838.5</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>517,648.0</b>	<b>1,162,343.0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>517,648.0</b>	<b>1,162,343.0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>517,648.0</b>	<b>1,162,343.0</b>
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-517,648.0</b>	<b>1,162,343.0</b>

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-98,500.0	
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,500.0	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	71,900.8	387,495.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	231,534.2	303,435.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	303,435.0	495,221.4

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,025,944.0	5,025,944.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	259.0	259.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,026,203.1	5,026,203.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-279.6	-279.6
9	Тайлант үеийн үр дүн	3,427,189.1	3,427,189.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,453,112.6	8,453,112.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,453,112.6	8,453,112.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-859.1	-859.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,452,253.6	8,452,253.6
19	Тайлант үеийн үр дүн	963,647.2	963,647.2
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	9,415,900.7	9,415,900.7

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2623399.7	2381324.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1861240.1	1796563.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1776498.7	1711954.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	792489.3	790127.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99061.3	99635.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	653929.5	604175.4
2104	Хангамж, бараа материалын зардал	27336.2	27069.2
2105	Нормативт зардал	553.7	480.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15118.8	14796.8
2107	Томилолт, зочны зардал	9459.3	9385.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101231.9	92961.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77318.7	73323.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84741.4	84608.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	84741.4	84608.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	662159.6	584761.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100000.0	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2623399.7	2357167.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2268736.4	2284700.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	354663.3	72466.4
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	64	64
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	31	31

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	31	31
----	---------------------	----	----

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2023 оны дүн	2024 оны дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	232081.9	1,313,546.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90773.6	740,181.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90773.6	721,738.19
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35428.8	692,022.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		26,338.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18,443.54
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	17659.5	18,443.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	123648.8	573,364.90
2200	Дотоод эх үүсвэрээр		573,364.90
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	232081.9	1,313,546.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232081.9	1,313,546.63

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ОНХС тай холбоотой нийт 278,405.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил илэрснээс аудитын явцад 23,020.9 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) нэмэлт санхүүжилтийн дансанд орсон 23,020.9 мянган төгрөгийн орлогын ангилал буруу дансанд бичигдсэн мөн төвлөрүүлэх шилжүүлгийг зөрүүлсэн байсныг залруулсан.

Залруулагдаагүй нийт 255,384.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Нийт 255,384.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 255,384.8 мянган төгрөгийн 5 заалт бүхий зөвлөмж бичлээ.

### 5.1 Зөвлөмж

#### 5.1.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Босго үнээс давсан ажлуудыг задалж худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулж ажил гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлуулах саналыг сумын ИТХ-д оруулахдаа зориулалт болон хүчин чадал, нэршил, байршил нь ижил арга хэмжээг нийт дүнгээр нь батлуулан хуулийн хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгаан илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **5.1.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй дэд хөтөлбөрүүд болон малын тоо толгойн албан татвараас урсгал зардал баталсан. Үүнд: /Аварга хөтөлбөр, Бусад хөтөлбөр арга хэмжээ, Гэр цэцэрлэгийн урсгал засвар, ногоон байгууламж тохижилт/ гэх мэт: Уг хөтөлбөрүүдээс Засаг даргын захирамжаар, багшийн шагналын мөнгө, тэмцээний шагналын зардал олгосон урсгал үйл ажиллагаанд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4. "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй", ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.4. "Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ" гэсэн заалтыг мөрдөөгүй,

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр арга хэмжээ нэрийн дор урсгал үйл ажиллагааг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож хөтөлбөрийн хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тооцон ажиллах.

### **5.1.3 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой**

Илрүүлэлт Сумын ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх 243.9 сая төгрөгийн үнэ бүхий 11 нэр төрлийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн бүртгэлд тусгаагүй, эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүргийг хүлээнэ", 20,2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгийн асуудлыг сумын ИТХ-ын шийдвэр гаргуулж дараа оны санхүүгийн тайланд хөрөнгөд бүртгэх

### **5.1.4.Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Шилэн дансны цахим сайтад мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д Энэ хуульд зааснаар, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд, төсвийн ерөнхийлөн захирагчид, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг эзэмшиж байгаа компаниуд, төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүд шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд оруулах үүрэгтэй; Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ, 6.2-д Энэ хуулийн 6.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна, 6.3-т Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна, 6.4-д Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

### **5.1.5. Татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой**

Илрүүлэлт: Тайлант онд төрийн албан хаагч нарын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 131,259.3 мянган төгрөгөөр давж биелснээс

үүдэн татварын орлого нийт дүнгээрээ 184,210.9 мянган төгрөгөөр давж биелсэн боловч бусад татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 21,059.9 мянган төгрөгөөр тасарсан зөрчил дутагдал нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.2.2.-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 6.2.3-т “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 -д “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн орлогыг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэн ажиллах .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТАР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛГИЙН НЭГТГЭЛ

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Загруулсан		Загруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	0	1	23,020.9			1	23,020.9				
Дүн	1	0	1	23,020.9	0	0	1	23,020.9	0	0	0	0

## 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
			Төлбөрийн акт		Албан шаардлага				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх 234.3 сая төгрөгийн үнэ бүхий 11 нэр төрлийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй	1	234,324.9			1	234,324.9				
Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө тасарсан.	1	21,059.9					1	21,059.9		
Дүн	2	255,384.8	-	-	-	-	5	255,384.8		

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган тэгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:											
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
2	3	4	5	6	7	8	9	10	11	12				
Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн шалгуур тооцдоггүй	1	0					1	0						
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй	1	0					1	0						
Худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас зайлсхийж төсөл арга хэмжээг жижигтэн батлуулж санхүүжүүлсэн	1	0					1	0						
	3	0					3	0						